



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

САНГИЙН ЯАМ

ИРГЭДИЙН ТӨСӨВ

НЭГДСЭН ТӨСВИЙН 2019 ОНЫ
I-II УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ


Улаанбаатар хот
2019 он

Санал хүсэлтээ дараах хаягаар илгээнэ үү.

 tusuv@mof.gov.mn

 www.mof.gov.mn

 www.iltod.gov.mn

 Монгол Улсын Сангийн яам, С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр, Д корпус, Улаанбаатар 15160, Монгол Улс

Монгол улсын нэгдсэн төсвийн 2019 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлийн мэдээ



Монгол улсын нэгдсэн төсвийн 2019 оны хагас жилийн гүйцэтгэлийн мэдээ



2019 оны төсвийг батлахдаа Засгийн газар **ЦАХИМ, ИЛ ТОД, ҮР АШИГТАЙ** төсвийн бодлогыг баримталсан

ТӨСВИЙН ТЭНЦЭЛ	Төсвийн алдагдлыг үе шаттай бууруулж, дотоодын нийт бүтээгдэхүүний 5.4 хувьд хүргэнэ.
ТӨСВИЙН ОРЛОГО	Татварын хуулийн шинэчлэл, Гаалийн шинэчлэл, Орон нутгийн орлогын шинэчлэлийг хэрэгжүүлнэ.
ТӨСВИЙН ЗАРЛАГА	Төсвийн зарлагын шинэчлэлийг хэрэгжүүлж, үр ашигтай хуваарилахад технологийн дэвшлийг нэвтрүүлэн, ил тод байдлыг сайжруулна.
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	Нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, үр ашгийг сайжруулна.
ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖ	Гадаадын зээл, тусламжийг эдийн засаг, нийгэм, дэд бүтцийн үр ашигтай төсөлд зарцуулна.
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨР	Өрийн өнөөгийн үнэ цэнэ болон дотоодын нийт бүтээгдэхүүний харьцааг 55.3 хувь болгож, хүүгийн зардлыг бууруулна.
ОРОН НУТГИЙН ТӨСӨВ	Төсвийн төвлөрлийг сааруулж, орон нутгийн өмчийг эзэнд нь хариуцуулах замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.



Монгол Улсын 2020 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон эдгээр хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу **2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр** УИХ-д өргөн барьсан нь энэ улирлын онцлог байлаа.

2019 ОНЫ БАТЛАГДСАН НЭГДСЭН ТӨСВИЙН ҮР ДҮНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ЭРГЭН ХАРЬЯ.



ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО


9,676.5 тэрбум

Орлогын эх үүсвэр хаанаас бүрддэг вэ?

ТӨСВИЙН ЗАРЛАГА

11,589.1 тэрбум

Орлогыг юунд зарцуулах вэ?



Тэнцвэржүүлсэн тэнцэл
-1,912.6
тэрбум

ТӨСВИЙН ОРЛОГО

I-III улирлын гүйцэтгэл




2019 оны 3-р улирлын гүйцэтгэлийн мэдээг толилуулъя. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого Ирээдүйн өв сан, Төсвийн тогтворжуулалтын сан болон тэнцвэржүүлсэн орлогоо бүрдэнэ.

ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО

8,656.7

ТЭРБУМ ТӨГРӨГ

↑ 20.5% Өмнөх оны мөн үеэс өөрчлөлт



Ирээдүйн өв сан нь эрдэс баялгаас бий болсон орлогын тодорхой хэсгийг ирээдүй хойч үедээ зориулан хадгалж буй сан юм.



Төсвийн тогтворжуулалтын сан нь гол нэр төрлийн эрдэс, түүхий эдийн үнийн өөрчлөлтөөс хамаарсан төсвийн орлогын хэлбэлзлийг тогтворжуулах, мөн төсвийн алдагдлыг нөхөх зориулалттай сан юм.



ОНЦЛОХ ОРЛОГО



Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

▲ 27.7%



Газрын төлбөр

▲ 65.4%



Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

▲ 29.2%

* өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

УУЛ УУРХАЙН ГОЛЛОХ ЭКСПОРТЫН

I-III улирлын гүйцэтгэл

Зэс

1,066.0 МЯН.ТН

▼ 1% : : : Өнгөрсөн оны мөн үеэс

Нүүрс

28.8 сая.ТН

▲ 5% : : : Өнгөрсөн оны мөн үеэс

Алт (Монгол Банканд тушаасан хэмжээ)

11.2 ТН

▼ 22% : : : Өнгөрсөн оны мөн үеэс

Төмөр

6,134.0 МЯН.ТН

▲ 15% : : : Өнгөрсөн оны мөн үеэс

ТАТВАРЫН ШИНЭЧЛЭЛ

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 3-р сарын 22-ны өдөр баталсан татварын багц хуулийг 2020 оны 1-р сарын 1-ний өдрөөс даган мөрдөж эхэлнэ.

ХҮРЭХ ҮР ДҮН:

Татварын ачаалал буурч жилд гаргах тайлангийн тоог цөөрүүлнэ.

50 сая төгрөг хүртэл

Борлуулалтын орлогын

1%

Хялбаршуулсан тайлан

1 удаа

Борлуулалтын орлого

300 сая төгрөг хүртэл

Татвар ногдуулах орлогын

1%

Тайлан

2 удаа

Борлуулалтын орлого

1.5 тэрбум төгрөг хүртэл

Татвар ногдуулах орлогын

10%

Тайлан

2 удаа

Төлсөн татварын буцаана **90%**

Татвар ногдуулах орлого

6 тэрбум төгрөг хүртэл

Татвар ногдуулах орлогын

10%

Тайлан

2 удаа

Татвар ногдуулах орлого

6 тэрбум төгрөгөөс дээш

Татвар ногдуулах орлогын

25%

Тайлан

4 удаа

“

Одоогийн хуульд **ЖИЛИЙН АШИГ**

3 тэрбум хүртэл **4 тайлан, 10% татвар,**
3-с дээш бол **4 тайлан, 25% татвар**

ИРГЭДИЙН ХУВЬД:

Орон сууц анх удаа худалдан авахад үзүүлэх **татварын хөнгөлөлт 3 саяаас 6 сая төгрөг болж нэмэгдэнэ.**

Ипотекийн зээлийн хүүгийн дээд хэмжээ болон ипотекийн хөнгөлөлттэй зээлийн хүүгийн зөрүүгээр **татварыг хөнгөлнө.**

Алслагдсан аймагт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгжийн **татварыг 50-90% хөнгөлнө.**

Хөдөө аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид тухайн бүтээгдэхүүнээс олсон орлогод ногдох **татварыг 50 хувиар хөнгөлнө.**

КОМПАНИЙН ХУВЬД:

Орлогын албан татварын босго **6 тэрбум төгрөг** болж өснө.

Татварын тайланг **1 жилийн дотор** залруулах боломжтой.

Хүндэтгэн үзэх шалтгаантай бол татварын өрийг **2 жил хүртэл хугацаанд** төлөх боломжтой.


ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ БОЛОН БУСАД ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсад бүртгэлтэй компанийн гадаад, дотоодын зах зээлд нээлттэй арилжаалах бондод хөрөнгө оруулагчийн **хүүгийн орлогын татвар 5%**

Гадаад улсад төлсөн татварыг хасагдуулна

Барилга байгууламжийн элэгдэл тооцох хугацаа **40-өөс 25 жил болно. (уул уурхайгаас бусад салбарт)**

ГААЛИЙН ШИНЭЧЛЭЛ



Экспорт, импортын бараа бүтээгдэхүүнд тавих хилийн хяналтыг сайжруулах, хэрэглэгч, үйлдвэрлэгчдийн эрх ашгийг хамгаалах, төсвийн орлогын суурийг өргөжүүлэх зорилгоор “Гаалийн шинэчлэл”-ийг хэрэгжүүлж эхэллээ.

РЕНТГЕН

Өндөр хүчин чадлын рентген болон хяналт шалгалтын тоног төхөөрөмж нэвтрүүлнэ.

- Эрдэс бүтээгдэхүүний чанар, агуулга, тоо хэмжээг бүрэн тодорхойлно.
- Газрын тосны бүтээгдэхүүний чанар, агуулга, тоо хэмжээг бүрэн тодорхойлно.
- Хууль бус, чанаргүй бараа, бүтээгдэхүүнийг илрүүлж, таслан зогсооно.



ЛАБОРАТОРИ

Экспортын бүтээгдэхүүн гарч байгаа хилийн боомтуудад олон улсын стандарт шаардлагад нийцсэн тоноглол, тоног төхөөрөмж бүхий уул уурхай **ЭРДСИЙН ТӨРӨЛЖСӨН ЛАБОРАТОРИЙГ** байгуулж татвар, хураамжийг бүрэн ногдуулж, хураадаг болно.

ТЕЛЕ ХЯНАЛТЫН СИСТЕМ

Гаалийн ерөнхий газрын дэргэд Шуурхай хяналт, удирдлагын төв байгуулан гаалийн нэгж, цэг бүрийг автомат **ТЕЛЕ ХЯНАЛТЫН СИСТЕМД** хамруулна.

УХААЛАГ ГАРЦ

Радио давтамжит долгионоор тээврийн хэрэгслийг бүртгэх **“УХААЛАГ ГАРЦ” ХЯНАЛТЫН СИСТЕМИЙГ** нэвтрүүлнэ.



БООМТУУДЫН ХҮЧИН ЧАДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ

ГОЛЛОХ БООМТУУДЫГ олон улсын түвшинд нийцүүлэн цогцоор нь шинэчилнэ


Замын-Үүд боомт

Зам, талбайн хэмжээ **8** дахин

Зорчигчдын тоо **4** дахин

Ачаа тээврийн хэрэгслийн тоо **3** дахин

Суудлын тээврийн хэрэгслийн тоо **7** дахин



Гашуунсухайт боомт

Зам, талбайн хэмжээ **4** дахин

Экспортын хүчин чадал **3** дахин

Ачаа, зорчигч, тээврийн хэрэгслийн тоо **3** дахин



Алтанбулаг боомт

Зам, талбайн хэмжээ **2** дахин

Зорчигчдын тоо **3** дахин


Ачаа, суудлын тээврийн хэрэгслийн тоо **4** дахин



ТӨСВИЙН ЗАРЛАГЫН I-III УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ



Монгол Улсын нэгдсэн төсөв нь дараах дөрвөн төсвөөс бүрдэнэ. УИХ болон Засгийн газрын харьяа байгууллагуудын зарцуулах төсвийг Улсын төсөв, аймаг, нийслэлийн зарцуулах төсвийг Орон нутгийн төсөв гэнэ. Нийгмийн даатгалын сангаас өндөр насны болон бусад тэтгэвэр, тэтгэмжийн зардал гардаг бол Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэн Таны эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлийг хуваалцаж байдаг.



МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГА

7,264.4 ТЭРБУМ ₮

ХҮҮГИЙН ТӨЛБӨР

627.1
ТЭРБУМ ТӨГРӨГ | **8.6%** ЭЗЛЭХ ХУВЬ

ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

1,061.6
ТЭРБУМ ТӨГРӨГ | **14.6%** ЭЗЛЭХ ХУВЬ

ЦАЛИН ХӨЛС

1,637.9
ТЭРБУМ ТӨГРӨГ | **22.5%** ЭЗЛЭХ ХУВЬ

ТАТААС, ШИЛЖҮҮЛЭГ


2,456.9
ТЭРБУМ ТӨГРӨГ | **33.8%** ЭЗЛЭХ ХУВЬ

ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ

1,320.3
ТЭРБУМ ТӨГРӨГ | **18.2%** ЭЗЛЭХ ХУВЬ

БУСАД ЗАРДАЛ


160.6
ТЭРБУМ ТӨГРӨГ | **2.2%** ЭЗЛЭХ ХУВЬ




УЛСЫН ТӨСВИЙН I-III улирлын гүйцэтгэл

НИЙТ **5,708.2** тэрбум
төгрөг

- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
- Эрүүл мэндийн сайд
- Батлан хамгаалахын сайд
- Зам, тээврийн хөгжлийн сайд
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
- Хууль зүй, дотоод хэргийн сайд
- Монгол Улсын Ерөнхий сайд
- Сангийн сайд




- Засгийн газрын хүүгийн төлбөр
- Гадаад зээл, тусламж
- Орон нутагт олгох дэмжлэг
- Бусад зардал



тэрбум төгрөг

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН I-III УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ



ХҮҮХДЭД ОЛГОХ МӨНГӨН ТЭТГЭМЖ

169.5 | **ЭЗЛЭХ ХУВЬ**
ТЭРБУМ ТӨГРӨГ | **33.6%**

Хүүхдийн мөнгө хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргасан өрхийн хүүхэд бүрд сар бүр 20,000 ₮



ЦАЛИНТАЙ ЭЭЖ ХӨТӨЛБӨР

73.5 | **ЭЗЛЭХ ХУВЬ**
ТЭРБУМ ТӨГРӨГ | **14.6%**

0-3 насны хүүхэд асрахад сар бүр 50,000 ₮
0-18 насны 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд улирал бүр 320,000 ₮



ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ТУСЛАМЖ, ДЭМЖЛЭГ

27.1 | **ЭЗЛЭХ ХУВЬ**
ТЭРБУМ ТӨГРӨГ | **5.4%**

Том хүнд сар бүр 16,000 ₮
Хүүхдэд сар бүр 8,000 ₮



ХАЛАМЖИЙН ТЭТГЭВЭР

ЭЗЛЭХ ХУВЬ | **85.5**
16.9% | ТЭРБУМ ТӨГРӨГ

2019 оны 2-р сарын 1-ний өдрөөс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлсэн. Тэтгэвэр 155,000-аас 174,000 ₮ Тэтгэмж 70,000-аас 76,000 ₮



НӨХЦӨЛТ МӨНГӨН ТУСЛАМЖ

ЭЗЛЭХ ХУВЬ | **35.1**
7.0% | ТЭРБУМ ТӨГРӨГ

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.3-д заасан хувь хэмжээгээр олгоно.



АЛДАРТ ЭХИЙН ОДОНТОЙ ЭХЧҮҮДЭД ОЛГОХ ТЭТГЭМЖ

ЭЗЛЭХ ХУВЬ | **28.9**
5.7% | ТЭРБУМ ТӨГРӨГ

I-р одонтой ээжид жилд 1 удаа 200,000 ₮
II-р одонтой ээжид жилд 1 удаа 100,000 ₮

БУСАД

ЭЗЛЭХ ХУВЬ | **85.4**
16.9% | ТЭРБУМ ТӨГРӨГ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САН

Эрүүл мэндийн даатгалын сангийн 2019 оны 3-р улирлын гүйцэтгэл 237.2 тэрбум төгрөг. Үүнээс дийлэнх хэсэг болох 162.5 тэрбум төгрөг буюу 68.5 хувийг улсын хэвшлийн эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлсэн даатгуулагчдад үзүүлэх хөнгөлөлт, өөрөөр хэлбэл Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд өгөх шилжүүлэгт зарцуулсан байна.




ОНЦЛОХ ЗАРДЛУУД



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН

Нийгмийн даатгалын сангийн зардал 1,531.0 тэрбум төгрөг бөгөөд 2019 оны 9 сарын 30-ны өдрийн байдлаар 99 хувийн гүйцэтгэлтэй байна.



I-III улирлын ГҮЙЦЭТГЭЛ

Монгол Улсын 2019 оны төсөвт улсын болон концессын нийт 1,698.1 тэрбум төгрөгийн 1,293 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тусгаж баталсан. Үүний 31.4 хувь нь он дамжин хэрэгжих, 68.4 хувь нь 2019 онд шинээр хэрэгжих төслүүд юм.

Улсын төсөв
1,281 төсөл
1,553.4
тэрбум төгрөг

“Барих-Шилжүүлэх”
концесс
12 төсөл
144.7
тэрбум төгрөг

Төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл
2019 оны эхний 3 улирлын байдлаар
653.9 тэрбум төгрөгийн
санхүүжилт хийгдэж, гүйцэтгэл
38.5 хувьтай байна.

**Батлан
хамгаалахын
сайд**

Гүйцэтгэлийн дүн

8.0

Тэрбум төгрөг



**Зам, тээврийн
хөгжлийн сайд**

Гүйцэтгэлийн дүн

97.8

Тэрбум төгрөг



**Засгийн газрын
хэрэг эрхлэх
газрын дарга**

Гүйцэтгэлийн дүн

11.7

Тэрбум төгрөг



**Боловсрол, соёл, шинжлэх
ухаан, спортын яам**

Гүйцэтгэлийн дүн

205.0

Тэрбум төгрөг




**Барилга хот
байгуулалтын яам**

Гүйцэтгэлийн дүн

56.6

Тэрбум төгрөг



**Эрчим
хүчний сайд**

Гүйцэтгэлийн дүн

52.3

Тэрбум төгрөг



**Хөдөлмөр,
нийгмийн
хамгааллын сайд**

Гүйцэтгэлийн дүн

11.7

Тэрбум төгрөг




**Хууль зүй
дотоод хэргийн
сайд**

Гүйцэтгэлийн дүн

28.7

Тэрбум төгрөг



**Эрүүл
мэндийн сайд**

Гүйцэтгэлийн дүн

23.4

Тэрбум төгрөг



Концесс

Гүйцэтгэлийн дүн

114.9

Тэрбум төгрөг




Бусад

Гүйцэтгэлийн дүн

43.8

Тэрбум төгрөг




ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИНЭЧЛЭЛ

Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үйл ажиллагааг онлайн болгож,



<https://publicinvestment.gov.mn>

веб хуудас болон гар утасны аппликэйшнийг ажиллуулж байна.



Санхүүжилтийн үйл ажиллагааг түргэн шуурхай хэрэгжүүлэх



Иргэд, олон нийтийг мэдээллээр ил тод, нээлттэй хангах




Төрийн үйлчилгээнд хувийн хэвшил, олон нийт хяналт тавих боломжийг бүрдүүлэх



Гүйцэтгэгч аж ахуй нэгж гэрээт ажлын санхүүжилтийг ямар үе шатанд явж байгааг нээлттэй харах, хянах




Иргэд тухайн орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл авах



Иргэдийн төсөв

Нэгдсэн төсвийн 2019 оны I-III улирлын гүйцэтгэл

Засгийн газрын өрийн I-III улирлын гүйцэтгэл




Монгол Улсын Засгийн газар 2019 оны 3-р улирлын байдлаар

Үндсэн төлбөрт: **513.3 тэрбум**

Хүүгийн төлбөрт: **627.1 тэрбум**

Нийт: **1,140.4 тэрбум** төгрөг төлжээ


ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ДАРАМТ БУУРЧ БАЙНА



2019 оны 9 сарын 30-ны өдрийн байдлаар **646 тэрбум** төгрөгийн зээлийг хөгжлийн түнш байгууллагууд болон гадаад улс орнуудаас авч ашиглажээ.


ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН I-III УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

2019 оны төсөвт 1,096.3 тэрбум төгрөгийн гадаад зээл, 146.0 тэрбум төгрөгийн гадаад тусламжаар нийт 132 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгаж, баталсан. 2019 оны 09 сарын 30-ны өдрийн байдлаар дараах томоохон төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлсэн байна



ЗАСГИЙН ГАЗРЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ЗАРЦУУЛАЛТЫГ ХӨГЖЛИЙН ТҮНШ БАЙГУУЛЛАГУУДААР ХАРВАЛ:

*тэрбум төгрөг



ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН I-III УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

21 АЙМАГ | НИЙСЛЭЛ
330 СУМ | 9 ДҮҮРЭГ

851.0
ТЭРБУМ ТӨГРӨГ



ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТУСЛАМЖ

97.8

тэрбум төгрөг



ГАЗРЫН
ХАРИЛЦАА,
КАДАСТР

9.0

тэрбум төгрөг



СУРГУУЛИЙН
ӨМНӨХ БОЛОВСРОЛ

254.0

тэрбум төгрөг



ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ
ХАМГААЛАЛ

6.0

тэрбум төгрөг



ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛ

477.7

тэрбум төгрөг



ЭРҮҮЛ МЭНДИЙН
ДААТГАЛЫН САНГААС
САНХҮҮЖИХ

6.5

тэрбум төгрөг

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН
ШИЛЖҮҮЛЭГ

УЛСЫН ТӨСӨВ

УЛСЫН ТӨСВӨӨС ОРОН
НУТГИЙН ТӨСӨВ РҮҮ
САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

125.4

тэрбум төгрөг

Төсвийн зарлага нь орлогоосоо их буюу алдагдалтай байгаа тохиолдолд улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг олгодог.

ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС
УЛСЫН ТӨСӨВТ
ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО

176.8


тэрбум төгрөг

Төсвийн орлого нь зарлагаасаа их буюу ашигтай гарсан тохиолдолд орлогын тодорхой хувийг улсын төсөвт төвлөрүүлдэг.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН I-III УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ


ТЭРБУМ ТӨГРӨГ

2019 оны 3-р улирлын байдлаар орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан 92.6 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт шилжүүлсэн байна.



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН НЭГДСЭН САНГИЙН САНХҮҮЖИЛТ

ТЭРБУМ ТӨГРӨГ



Иргэдийн төсөв

Нэгдсэн төсвийн 2019 оны I-III улирлын гүйцэтгэл



САНГИЙН ЯАМ